

Дулаан боловсруултанд оруулсан германий монокристаллын эвдэрлийн энтропийг тодорхойлох

Г. Шилагарди¹, Э.М. Шпилевский², П. Түвшинтөр^{1,*}, Т. Отгончимэг³, Д. Улам-Оргих¹

¹Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх Ухааны Сургууль, Физикийн тэнхим

²Беларусын Их Сургууль, Минск, Беларусь


³Түмэн заг ХХК

Германий монокристаллыг өндөр температурт халаагаад буй болсон эвдрэл эдгэж амжихгүйгээр маш хурдтайгаар хатаасан. Ингэж хатаахад үүссэн эвдрэл тэр чигээрээ хадгалагдах ба системийн энтропи халаах температур, хатаалт явуулах хурд ихсэхэд улам ихснэ. Термоакцепторын концентрац германий монокристаллын хольцын атомын концентрацаас асар их байсан тул дээж р-дамжицтай болжээ.

Түлхүүр уг: Дефект, термодефект, донор ба акцептор.


ОРШИЛ

Хагас дамжуулагч бодисын цахилгаан дамжиц хольцоос хамаардаг. Амьдралд хэрэглэгддэг ихэнх хагас дамжуулагч бодисууд 4-р бүлгийн элемент юм. Эдгээрийн тоонд германий Ge, цахиур Si орно. Германий монокристаллын атомыг 5-р бүлгийн элементээр солиход н-дамжицтай 3-р бүгийн элементээр солиход р-дамжицтай болохоос гадна хаалттай зон дотор дамжуулалтын зоны ёроолоос 0,01 эВ зайнд орших, донорын түвшингүүд валентын зоны оройгоос мөн төдий чинээ зайнд орших акцепторын түвшин үүснэ. Тэдгээр түвшингүүд шингэн азотын температурт бүрэн ионждог (1-р зураг).



1-р зураг. Ионжсон донор ба акцепторын түвшингүүд.

Яагаад хаалттай зон дотор энержийн түвшин үүсч байна гэвэл, германий монокристаллын тор эвдэрч гажсан байна (2-р зураг). Үүнийг кристалл тор дотор деффект үүслээ гэдэг.




2-р зураг. Донор ба акцепторын хольцоос болсон торын гажиг.

Аливаа бодис ба системийн төлвийг тодорхойлох энтропи S хэмээх функц эвдрэл буй болж, эмх замбараагүй байдал ихсэхэд өсөх хуультай. Ингэхлээр хольцтой хагас дамжуулагчийн энтропи ихэссэнээс хаалттай зонд гүехэн энержийн түвшин үүсчээ.

ТУРШИЛТ ЯВУУЛАХ АРГАЧЛАЛ БА ТҮҮНИЙ ҮР ДҮН


Энэ санаагаа батлахын тулд бид германий монокристаллыг өндөр температурт халаагаад буй болсон эвдрэл эдгэж амжихгүйгээр маш хурдтайгаар хатаасан. Ингэж хатаахад үүссэн эвдрэл тэр чигээрээ хадгалагдах ба системийн энтропи халаах температур, хатаалт явуулах хурд ихсэхэд улам ихснэ. Энэ үед кристалл тор эвдэрснээс тусгараар ваканси, хоёр ваканси нийлсэн диваканси хэмээх том том эвдрэлүүд үүсэхэд хаалттай зон дотор акцепторын түвшингүүд үүсдэгийг холлын коэффициентын температурын хамааралын хэмжсэн туршилгын үр дүнгээс харж болно (3-р зураг).

*Electronic address: tuvshintur@num.edu.mn



3-р зураг. Холлын коэффициентын температурын хамаарал $\lg = f(\frac{1}{T})$, 1) 300°C; 2) 330°C; 3) 400°C; 4) 450°C; 5) 500°C; 6) 550°C; 7) 600°C; 8) 650°C; 9) 700°C;

Дулаан боловсруулалтад оруулах буюу хатаахад үүссэн эвдэрийг термодефект гэх бөгөөд валентын зоны оройгоос $Er+0.44$ эв зайнд орших акцепторын түвшинг үүсгэнэ (4-р зураг).




4-р зураг. Валентын зоны орой орчимд үүссэн акцепторын түвшингүүд.

Туршлагаар тодорхойлсон олдсон термоакцепторын концентрац ба температурын хамаарлыг доорх графикт дүрслэн үзүүллээ (5-р зураг).

Энэ муруйн налууг ашиглан тодорхойлоход термоакцепторын үүсэх энериgi ба $E_A=(2.0\pm0.1)$ эВ байсан түүний концентрац дараах томъёогоор тодорхойлогдож байлаа [1,2,3,4].

$$N = N_0 \exp\left(-\frac{E}{KT}\right) = 3 \cdot 10^{25} \exp\left(-\frac{2\text{эВ}}{KT}\right).$$

Термоакцепторын концентрац германий монокристаллын хольцын атомын концентрацаас асар их байсан тул дээж р-дамжицтай болжээ.



5-р зураг. Термоакцепторын концентрац хатаалтын темпертураас хамаарах хамаарал.

ТУРШЛГЫН ҮР ДҮНГ ШҮҮН ХЭЛЭЛЦЭХ БА ДҮГНЭЛТ

Германий монокристаллын 1cm^3 эзэлхүүн дэх атомын концентрац $4.42 \cdot 10^{22} \text{cm}^{-3}$ байдаг. Гэтэл экспонентын өмнөх гишүүн туршлагаар тодорхойлсноор $N_s=3 \cdot 10^{25} \text{cm}^{-3}$ байна. Нэгэн термодефектын тоо атомын концентрацаас их байж болохгүй тул дараах илэрхийлэлийг бичиж болно.

$$N_0 = N_s \cdot A = N_0 \cdot e^{\frac{S}{K}},$$

үүний N_s - кристаллын нэгж эзэлхүүн дэх атомын тоо, $A = \frac{S}{K}$ - термодефект үүсэх энтропийг агуулсан үржвэр болно. Эндээс термодефект үүсэх энтропийг олболж. $S = 6.52k$ болж байна [5,6,7]. Эндээс үндэслэн урд өмнө германий монокристалл ба бусад бодисыг дулаан боловсруулалт оруулах буюу өндөр энергитэй бөөмсөөр буудахад үүссэн эвдэрийг судлахдаа түүний үүслийн энтропийг тодорхойлох ерөнхий санааг дэвшүүлж байна.

НОМ ЗҮЙ

- [1] R.A. Logan, Phys. Rev., 101, 1455, 1956.
- [2] А.Д. Беляев, Л.И. Даценко, С.С. Малоголовец. Укр. Физ. Журн. 13. 654. 1967.
- [3] R.A. Logan, M.Schwartz; J.Appl.Phys.26. 1287. 1955.
- [4] S. Mayburg. Phys. Rev., 95. 38. 1954.
- [5] S. Mayburg, L. Rotondi. Phys.Rev., 91. 1015. 1953.
- [6] А. Дамаск и Дж. Динс. “Точечные дефекты в металлах”, М., 1966.
- [7] N. Letaw, J. Phys. Chem. Solids, 1, 100. 1956.